

Dobrá oboustranná komunikace mezi rodiči a školou je zásadní pro vzdělávání žáků. Rodiče žáků s odlišným mateřským jazykem mohou mít potíže v komunikaci s učiteli a vedením školy z důvodu nedostatečné znalosti českého jazyka. Nicméně existují možnosti a služby, díky nimž mohou rodiče ve spolupráci se školou tyto překážky překonat.

OSOBNÍ KOMUNIKACE

Pro osobní komunikaci s třídním učitelem jsou vyhrazené třídní schůzky a konzultační hodiny. Z bezpečnostních důvodů rodiče většinou nemají přístup do prostor školy. I proto je třeba sjednat si osobní schůzku mimo tyto příležitosti předem telefonicky nebo emailem.

Kromě rozhovoru s učiteli a vedením školy můžete získávat informace na nástěnce školy a v písemné podobě (např. informační letáky, školní noviny).

Na osobní schůzku je možné zajistit tlumočení interkulturních pracovníků nebo doprovod sociálních pracovníků neziskových organizací v případě, že dítě nebo rodič zatím nerozumí dostatečně česky. Tyto služby jsou zdarma. Školy mohou využívat také bezplatné tlumočení a překlady (zajištěné NPI).

- ❗ Není vhodné používat dítě jako tlumočnicka. Na děti to klade nepřiměřené nároky, zatěžuje je stresem a nutí je přebírat odpovědnost dospělých. Mimo to je tlumočení dětmi značně nespolehlivé.

TELEFONICKÁ KOMUNIKACE

Telefonické tlumočení je možné například bezplatně přes charitní tlumočnickou linku. Infolinky jsou dostupné v ukrajinštině, vietnamštině a mongolštině každé pondělí a středu. Do školy není vhodné volat v době výuky. Je vhodné škole předat kontakt na spolehlivou osobu, která rodiči přetlumočí informace v neodkladných situacích.

ONLINE

Základní informace o škole a kontakty na pracovníky školy najdete online na stránkách školy. Je zásadní založit si e-mail, který budete používat pro komunikaci se školou a přístup do online systému školy (Bakaláři, Škola online, EduKit apod.). Pro vstup do portálu je také nutné zadat uživatelské jméno a heslo, které získáte od třídního učitele. Na tomto portálu najdete elektronickou žákovskou knížku se známkami, rozvrh hodin, plán akcí školy a zprávy. Portál obvykle slouží i pro omlouvání nepřítomnosti. Je vhodné se domluvit na využívání automatického překladu, což je v případě neznalosti jazyka pro obě strany praktičtější než mluvená komunikace.

Důležité je aktivně se zajímat o vzdělávání dítěte. I když v komunikaci se školou pomáhá další osoba (sourozenec, tlumočnicka, chůva atd.) zodpovědnost leží vždy na rodičích.

UŽITEČNÉ ODKAZY:

- 👁️ Seznam interkulturních pracovníků v Praze: <https://metropolevsech.eu/cs/kontakty/seznam-interkulturnich-pracovniku/>
- 👁️ Překlady a tlumočení NPI pro ZŠ: <https://cizinci.npi.cz/kontakty/>
- 👁️ <https://cizinci.npi.cz/tlumoceni-a-preklady/preklady-zs/>
- 👁️ Seznam infolinek pro cizince: <https://www.charita.cz/jak-pomahame/doma/integrace-cizincu/infolinky-pro-cizince/>
- 👁️ Informace pro učitele, jak komunikovat s rodiči: <https://www.inkluzivniskola.cz/jak-komunikovat-s-rodici>

Эцэг эх, багш сургуулийн хооронд сайн харилцаа үүсэж чадвал тэр нь эргээд сурагчдын боловсролд эегээр нөлөөлдөг. Гадаадын хүүхдүүдийн эцэг эхчүүд чех хэл мэддэггүйгээсээ болоод багш болон сургуулийн удирдлагатай ойлголцохгүй байх нь олонтоо. Ийм тохиолдолд эдгээр саад бэрхшээлийг даван туулах боломж байдаг гэдгийг эцэг эхчүүд мэдэж аваасай гэсэн үүднээс бидний зүгээс үйлчилгээ, туслалцаа үзүүлэхэд бэлэн байдаг.

БАГШ НАРТАЙ БИЕЧЛЭН УУЛЗАХ

Эцэг эхийн хурал эсвэл сургуулиас товлосон хуваарийн дагуу анги даасан болон бусад багш нартай биечлэн уулзах боломжтой. Аюулгүй байдлыг хангах үүднээс сургуулийн байранд гадны хүн нэвтрэх боломжгүй байдаг тул эцэг эхийн хурал, багштай уулзах хуваариас бусад үед заавал урьдчилан утсаар эсвэл цахим шуудангаар уулзах цаг авна. Сургуулийн удирдлага, багш нартай биечлэн уулзахаас гадна мэдээллийг сургуулийн самбар, зар мэдээ, сургуулийн сонин зэргээс олох боломжтой.

Хүүхэд, хүүхдийн эцэг эх чех хэл сайн мэддэггүй тохиолдолд багш, сургуулийн удирдлагатай биечлэн уулзах үедээ төрийн бус байгууллагуудын орчуулагч, нийгмийн ажилтныг дагуулж очих боломжтой. Эдгээр үйлчилгээ нь үнэ төлбөргүй байдаг. Сургуулиуд ч гэсэн Үндэсний боловсролын хүрээлэнгээс (NPI) үзүүлж буй аман болон бичгийн орчуулгын үйлчилгээг үнэ төлбөргүй ашиглах боломжтой.

! Хүүхдээр хэлмэрчлүүлэх нь огт зохисгүй хэрэг. Ингэж хэлмэрчлүүлэх нь хүүхэдэд дарамттай байхаас гадна сандарч тэвдэх, өөрт нь ахадсан ачааг үүрэх нөхцлийг бий болгодог. Мөн хүүхдээр хийлгүүлсэн аман орчуулга хангалтгүй болдог.

БАГШ НАРТАЙ УТСААР ХАРИЛЦАХ

“Харита” ТТБ-аас үзүүлдэг утсаар хэлмэрчлэх үнэ төлбөргүй үйлчилгээний тусламжтайгаар багш нартай утсаар харилцах боломжтой. Уг үйлчилгээг долоо хоногийн Даваа, Лхагва гарагуудад украин, вьетнам, монгол хэлээр үзүүлдэг. Хичээлийн үеэр багш руу утсаар залгах нь тохиромжгүй тул эцэг эхтэй яаралтай холбоо барих шаардлагатай үед мэдээллийг шуурхай дамжуулж өгөх найдвартай хүний утасны дугаар үлдээвэл сайн.

БАГШ НАРТАЙ ОНЛАЙНААР ХАРИЛЦАХ

Сургуулийн тухай мэдээлэл, ажилтан, багш нартай холбоо барих утас, и-мэйл зэргийг тухайн сургуулийн цахим хуудсанд байршуулдаг. Сургуультай харилцах, Bakaláři, Škola online, EduKit зэрэг сургуулийн онлайн системд нэвтрэх өөрийн и-мэйл хаягтай байх нь чухал. Эдгээр портал сайтад нэвтрэхдээ хүүхдийнхээ ангийн багшаас авсан нэвтрэх нэр, нууц үгийг оруулна. Портал сайтад хүүхдийнхээ сурлагын түвшин, үзүүлэлт, хичээлийн цагийн хуваарь, сургуулиас зохион байгуулж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл авахаас гадна танай хүүхэд хичээлдээ явж чадахгүй болох үед мэдэгдэнэ. Хэл нэвтрэлцэхгүй тохиолдолд онлайн орчуулгын автомат систем ашиглан ойлголцох нь муу аман орчуулгаас дээр болов уу.

Хүүхдийнхээ төлөвшил, сурлагын түвшин, үзүүлэлтэд санаа тавьж идэвхтэй оролцох нь хамгаас чухал. Сургууль, багш нартай харилцахад хамаатан садан, орчуулагч, хүүхэд асрагч зэрэг бусад хүүмүүсийн тус дэмжлэг хэрэгтэй ч бүх хариуцлагыг зөвхөн хүүхдийн эцэг эх л үүрнэ.

ТАНД ХЭРЭГ БОЛЖ МАГАДГҮЙ МЭДЭЭЛЭЛ:

- 📍** Прага хотын соёл хоорондын харилцаанд зуучлагчдын жагсаалт: <https://metropolevsech.eu/cs/kontakty/seznam-interkulturnich-pracovniku/>
- 📍** Бага сургуулиудад (ZŠ) зориулсан Үндэсний боловсролын хүрээлэнгийн (NPI) орчуулах, хэлмэрчлэх үйлчилгээ: <https://cizinci.npi.cz/kontakty/>
- 📍** <https://cizinci.npi.cz/tlumoceni-a-preklady/preklady-zs/>
- 📍** Гадаадын иргэдэд үйлчилгээ үзүүлдэг лавлах утасны жагсаалт: <https://www.charita.cz/jak-pomahame/doma/integrace-cizincu/infolinky-pro-cizince/>
- 📍** Багш нарт зориулсан “Эцэг, эхчүүдтэй хэрхэн харилцах вэ” сэдэвт мэдээлэл: <https://www.inkluzivniskola.cz/jak-komunikovat-s-rodici>